



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/96

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж" Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарын гамшигт үзэгдэл болсонтой холбогдуулан хохирлын үнэлгээ тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч:	Л.Доржбат	(Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	М.Адъяабаатар	(Онцгой байдлын газрын дарга)
	Г.Наранбаатар	(Цагдаагийн газрын дарга)
	Н.Эрдэнэ-Очир	(Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	Б.Энхтуяа	(Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтсийн дарга)
	Г.Энхтайван	(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Б.Мөнхжаргал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
	Ш.Мөнхдүүрэн	(Мал эмнэлгийн газрын дарга)
	Я.Мажаасүрэн	(Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Нарийн бичиг: Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга)

2. Аймгийн хэмжээнд үүссэн нөхцөл байдлын талаарх хохирлын үнэлгээг шуурхай тогтоож нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



481210257

Аймгийн засаг даргын 2021 оны 09  
дугаар сарын 22-ны өдрийн 1/64  
дүгээр захирамжийн хавсралт

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР  
2021 ОНД ШИНЭЭР ГАРГАХ ГҮН ӨРМИЙН ХУДГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Багийн нэр	Худаг гаргах газрын нэр	Сумаас алслах зүг	Км
1	Гурвансайхан	Чулуут	Буурал	Хойш	30
2	Гурвансайхан	Дэрсэнэ-Ус	Хөх овоо	Баруун хойш	28
3	Гурвансайхан	Дэрсэнэ-Ус	Хэцүүгийн хөх овоо	Баруун урд тал	40
4	Гурвансайхан	Элгэн	Их газрын чулуу дотор	Зүүн хойш	28
5	Говь-Угтаал	Морьт баг	Амана-Ус	Хойш	33
6	Говь-Угтаал	Ажирхай	Талбулаг	Баруун	25
7	Говь-Угтаал	Хонгор	Холбоо ар	зүүн	32
8	Өндөршил	Талын нар	Хүзүүвчин	Зүүн урд	25
9	Өндөршил	Цог	Бомбогор	Зүүн хойд	30
10	Сайнцагаан	Далай	Хаалган хад	Зүүн	45